

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2026/098/НА-СТА-ТШЗ

Чингис хот 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn Аудитор: Х.Баярбаатар Утас: 99058696 Цахим хаяг: bayarbaatarkha@audit.gov.mn Цахим хаяг: www.audit.mn
-----------------------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	11
5. Аудитын тайлангийн хавсралт	12

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХөрөнгө	Засаг даргын нөөц хөрөнгө
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР**

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.03.16 № 480
танай _____ -ны № _____ -т

Г ХЭНТИЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН Г
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Д.ДАШНАМЖИЛМАА ТАНАА

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний улмаас Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсан байна гэж үзлээ. Үүнд:

- Тайлант оны 9 дүгээр сард төсвийн тодотголоор 27,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий автомашин худалдан авах цахим тендер зохион байгуулж, төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.
- Тайлант онд 1 ажилтны ээлжийн амралтын олговрыг 2,529.8 мянган төгрөгөөр илүү олгож, төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан.
- Эрүүл мэндийн яамнаас хуваарилагдаж ирсэн эмнэлгийн зориулалттай 11 нэр төрлийн 51 ширхэг тоног төхөөрөмж, 3 нэр төрлийн 30 ширхэг тавилга, эд хогшлыг сумдад хуваарилсан боловч данс бүртгэлээс хасаж, шилжүүлэх арга хэмжээг авч ажиллаагүй байна.
- Шилэн дансны цахим системд 3,938,998.9 мянган төгрөгийн 26 гүйлгээг байршуулаагүй байна.
- Тус байгууллага нь санхүүгийн тайлангийн иж бүрдлийг хангаагүй, санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд зөрүүтэй тайланг хуульд заасан хугацаанаас 30 хоногоор

хэтрүүлсэн буюу 2026 оны 2 дугаар сарын 24-ний өдөр Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

Дээрх зөрчлүүд нь Шилэн дансны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцэхгүй бөгөөд санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь улсын төсвөөс 3,522,081.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 3,440,415.0 мянган төгрөг зарцуулж, 81,666.2 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтийн дансанд Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан 164,673.0 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан 141,652.1 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 595.0 мянган төгрөг, нийт 306,920.1 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 306,916.5 мянган төгрөгийг зарцуулан, 3.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллагын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 5,434,459.4 мянган төгрөгийн 9 алдаа зөрчил илэрснээс санхүүгийн тайланд 1,351,431.6 мянган төгрөгийн 5 алдааг залруулж, 2,529.8 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 4,080,498.0 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 59 арга хэмжээ тусгагдаж, 96.0 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	457,471,800.07	28,144,115.03
35	БАРАА МАТЕРИАЛ	457,471,800.07	28,144,115.03
351	Түүхий эд материал	281,900,935.73	11,726,042.46
35130	Эм боох материал	281,900,935.73	11,726,042.46
354	Хангамжийн материал	175,570,864.34	16,418,072.57
35410	Бичиг хэргийн материал	260,000.00	00.00
35420	Аж ахуйн материал	98,685,333.12	11,278,072.57
35430	Сэлбэг хэрэгсэл	11,222,510.10	500,000.00
35470	Бусад хангамжийн материал	65,403,021.12	4,640,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	891,423,382.83	860,741,010.39
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	891,423,382.83	860,741,010.39
392	Биет хөрөнгө	851,423,382.83	804,741,010.39
39201	Барилга, байгууламж, орон сууц	736,971,500.00	736,971,500.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-75,357,150.00	-90,130,008.36
39203	Авто-тээврийн хэрэгсэл	302,888,536.99	329,888,536.99
39204	Хуримтлагдсан элэгдэл	-214,688,536.97	-225,163,537.01
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	327,505,524.64	327,505,524.64
39206	Хуримтлагдсан элэгдэл	-256,517,339.27	-298,212,611.69
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	99,722,029.43	99,722,029.43
39208	Хуримтлагдсан элэгдэл	-69,101,181.99	-75,840,423.61
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,061,505.20	14,061,505.20
39215	Хуримтлагдсан элэгдэл	-14,061,505.20	-14,061,505.20
393	Биет бус хөрөнгө	40,000,000.00	56,000,000.00
39301	Програм хангамж	462,000.00	462,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-462,000.00	-462,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	40,000,000.00	56,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,348,895,182.90	888,885,125.42
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,980,400.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,980,400.00	00.00
413	Өглөг	3,980,400.00	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	3,980,400.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,344,914,782.90	888,885,125.42
51	Засгийн газрын хувь оролцоо	1,344,914,782.90	888,885,125.42
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	876,621,728.80	892,621,728.80
51101	Өмч: - төрийн	876,621,728.80	892,621,728.80
512	Хуримтлагдсан үр дүн	453,052,290.18	-18,977,367.30
51210	Өмнөх үеийн үр дүн	453,052,290.18	453,052,290.18
51220	Тайлант үеийн үр дүн		-472,029,657.48
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	15,240,763.92	15,240,763.92
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,348,895,182.90	888,885,125.42

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	4,003,735,965.55	4,386,144,987.32
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	558,780,991.55	557,143,665.98
120	Нийтлэг татварын бус орлого	558,780,991.55	557,143,665.98
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	558,780,991.55	557,143,665.98
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	91,492.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Бараа материал	558,780,991.55	557,052,173.98
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,444,954,974.00	3,829,001,321.34
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,253,017,626.00	3,522,081,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,253,017,626.00	3,522,081,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	191,937,348.00	306,920,121.34
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	34,899,600.00	164,673,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	156,372,748.00	141,652,121.34
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	665,000.00	595,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,587,259,986.50	3,871,794,785.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,587,259,986.50	3,871,794,785.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,836,887,384.79	1,671,974,076.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	908,756,234.34	1,001,942,006.79
210101	Үндсэн цалин	531,382,237.93	613,118,291.92
210102	Нэмэгдэл	261,238,745.88	256,956,478.32
210103	Унаа хоолны хөнгөлөлт	39,014,800.00	62,035,006.96
210104	Урамшуулал	77,120,450.53	69,832,229.59
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	115,367,236.88	113,258,806.76
210201	Тэтгэврийн даатгал	78,404,141.39	81,071,649.67
210202	Тэтгэмжийн даатгал	9,576,893.10	9,300,161.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,104,754.04	5,147,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,597,372.11	3,607,854.79
210205	Эрүүл мэндийн даатгал	17,684,076.24	14,131,540.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,551,886.07	51,222,780.06
210301	Гэрэл, цахилгаан	6,428,670.07	6,880,416.06
210302	Түлц, халаалт	45,276,216.00	42,284,744.00
210303	Цэвэр, бохир ус	4,847,000.00	2,057,620.00
2104	Хангамж, бараа материалын зардал	49,992,250.00	36,509,006.00
210401	Бичиг хэрэг	4,602,000.00	6,726,225.00
210402	Тээвэр, шатахуун	42,984,400.00	22,860,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,393,950.00	1,184,081.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,011,900.00	5,738,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	292,455,400.00	70,936,480.00
210601	Багаж, техник, хэргэсэл	271,375,100.00	47,946,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэргэглэл	00.00	416,000.00
210604	Урсгал засвар	21,080,300.00	22,573,880.00
2107	Томилдолт, зочны зардал	30,098,400.00	2,530,000.00
210702	Дотоод албан томилдолт	30,098,400.00	2,530,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,824,335.00	9,762,255.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,859,995.00	797,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,700,000.00	2,250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	576,900.00	516,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	208,040.00	217,855.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	33,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,413,400.00	5,946,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	372,932,882.50	385,812,741.78
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	267,642,486.00	312,130,369.34
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	104,780,396.50	73,682,372.44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,750,372,601.71	2,199,820,709.39
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,640,511,195.00	2,118,150,861.72
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	581,466,191.00	1,051,234,861.72
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,051,268,004.00	1,065,916,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,777,000.00	1,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	109,861,406.71	81,669,847.67
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	109,861,406.71	81,669,847.67
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	416,475,979.05	514,350,201.54
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	621,710,578.62	986,379,859.02
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	621,710,578.62	986,379,859.02
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-621,710,578.62	-986,379,859.02
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-205,234,599.57	-472,029,657.48

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,444,954,974.00	3,829,092,813.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	91,492.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	91,492.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	91,492.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	91,492.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,444,954,974.00	3,829,001,321.34
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,253,017,626.00	3,829,001,321.34
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,253,017,626.00	3,522,081,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	191,937,348.00	306,920,121.34
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,гүүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	34,899,600.00	164,673,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	156,372,748.00	141,652,121.34
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	665,000.00	595,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,444,954,974.00	3,829,220,813.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,444,954,974.00	3,829,220,813.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,709,008,338.29	1,629,400,103.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	908,756,234.34	1,001,942,006.79
210101	Үндсэн цалин	531,382,237.93	613,118,291.92
210102	Нэмэгдэл	261,238,745.88	256,842,304.22
210103	Унаа хоолны хөнгөлөлт	39,014,800.00	62,035,006.96
210104	Урамшуулал	77,120,450.53	69,946,403.69
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	115,367,236.88	117,239,206.76
210201	Тэтгэврийн даатгал	78,404,141.39	85,052,049.67
210202	Тэтгэмжийн даатгал	9,576,893.10	9,300,161.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,104,754.04	5,147,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,597,372.11	3,607,854.79
210205	Эрүүл мэндийн даатгал	17,684,076.24	14,131,540.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,551,886.07	51,222,780.06
210301	Гэрэл, цахилгаан	6,428,670.07	6,880,416.06
210302	Түлш, халаалт	45,276,216.00	42,284,744.00
210303	Цэвэр, бохир ус	4,847,000.00	2,057,620.00
2104	Хангамж, бараа материалын зардал	49,992,250.00	38,093,006.00
210401	Бичиг хэрэг	4,602,000.00	6,726,225.00
210402	Тээвэр, шатахуун	42,984,400.00	24,444,000.00
210403	Шуудан, холбоо, интэрнэтийн төлбөр	1,393,950.00	1,184,081.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,011,900.00	5,738,700.00
2105	Нормативт зардал	1,568,760.00	00.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	868,760.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	700,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	295,988,600.00	97,936,480.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	271,375,100.00	74,946,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,533,200.00	416,000.00
210604	Урсгал засвар	21,080,300.00	22,573,880.00
2107	Томилголт, зочны зардал	30,098,400.00	2,530,000.00
210702	Дотоод албан томилолт	30,098,400.00	2,530,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,824,335.00	9,762,255.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,859,995.00	797,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,700,000.00	2,250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	576,900.00	516,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	208,040.00	217,855.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	33,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,413,400.00	5,946,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	240,860,636.00	310,674,369.34
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	240,350,636.00	310,674,369.34
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	510,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,735,946,635.71	2,199,820,709.39
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,640,511,195.00	2,118,150,861.72
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	581,466,191.00	1,051,234,861.72
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,051,268,004.00	1,065,916,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, сигнал урамшуулал	7,777,000.00	1,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	95,435,440.71	81,669,847.67
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	95,435,440.71	81,669,847.67

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	836,738,409.10	4,341,541.00	-22,959,605.57	00.00	818,120,344.53
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	2,318,491.73	00.00	2,318,491.73
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	836,738,409.10	4,341,541.00	-20,641,113.84	00.00	820,438,836.26
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	-2,318,491.73	00.00	00.00	-2,318,491.73
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайланг үеийн үр дүн	-116,680.30	00.00	-610,428.45	00.00	-727,108.75
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	876,621,728.80	15,240,763.92	453,052,290.18	00.00	1,344,914,782.90
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	876,621,728.80	15,240,763.92	453,052,290.18	00.00	1,344,914,782.90
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	876,621,728.80	15,240,763.92	453,052,290.18	00.00	1,344,914,782.90
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	16,000,000.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайланг үеийн үр дүн	00.00	00.00	-472,029,657.48	00.00	-472,029,657.48
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	876,621,728.80	15,240,763.92	-18,977,367.30	00.00	888,885,125.42

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,573,645,400.00	3,440,415,004.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,573,645,400.00	3,440,415,004.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,420,900,300.00	1,322,264,142.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,038,447,800.00	1,001,942,006.79
210101	Үндсэн цалин	633,670,400.00	613,118,291.92
210102	Нэмэгдэл	274,465,100.00	256,842,304.22
210103	Унаа хоолны хөнгөлөлт	52,837,500.00	62,035,006.96
210104	Урамшуулал	77,474,800.00	69,946,403.69
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	149,760,400.00	117,239,206.76
210201	Тэтгэврийн даатгал	108,965,500.00	85,052,049.67
210202	Тэтгэмжийн даатгал	10,232,100.00	9,300,161.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,147,600.00	5,147,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,083,200.00	3,607,854.79
210205	Эрүүл мэндийн даатгал	20,332,000.00	14,131,540.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,764,000.00	51,222,780.06
210301	Гэрэл, цахилгаан	17,675,500.00	6,880,416.06
210302	Түлш, халаалт	44,741,600.00	42,284,744.00
210303	Цэвэр, бохир ус	4,346,900.00	2,057,620.00
2104	Хангамж, бараа материалын зардал	42,025,000.00	36,509,006.00
210401	Бичиг хэрэг	7,406,200.00	6,726,225.00
210402	Тээвэр, шатахуун	24,942,900.00	22,860,000.00
210403	Шуудан, холбоо, интернэгийн төлбөр	1,264,800.00	1,184,081.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,384,200.00	5,738,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	99,625,100.00	97,936,480.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	75,573,700.00	74,946,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,065,400.00	416,000.00
210604	Урсгал засвар	22,986,000.00	22,573,880.00
2107	Томилолт, зочны зардал	7,031,200.00	2,530,000.00
210702	Дотоод албан томилолт	7,031,200.00	2,530,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	10,533,700.00	9,762,255.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ	797,600.00	797,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,751,400.00	2,250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	516,800.00	516,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	233,600.00	217,855.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,300.00	33,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,174,000.00	5,946,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,252,600.00	5,122,408.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,252,600.00	5,122,408.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,152,745,100.00	2,118,150,861.72
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,152,745,100.00	2,118,150,861.72
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэвэр	1,073,344,200.00	1,051,234,861.72
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,078,400,900.00	1,065,916,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,573,645,400.00	3,440,415,004.33
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,573,645,400.00	3,440,415,004.33
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,573,645,400.00	3,440,415,004.33
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	39	35
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	29	25
620003	Үйлчлэх ажилтан	9	9

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	306,920,121.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	306,920,121.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	306,920,121.34
2104	Хангамж, бараа материалын зардал	9,336,360.00
210402	Тээвэр, шатахуун	9,336,360.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	297,580,109.34
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	297,580,109.34
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,652.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	3,652.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	306,920,121.34
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	306,920,121.34
131103	ЗГНХ,ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	164,673,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	141,652,121.34
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	595,000.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад 1,351,431.6 мянган төгрөгийн 5 алдааг санхүүгийн тайланд залруулсан. Үүнд:

Залруулсан алдаа:

1. Сэлбэг хэрэгсэл, бичиг хэрэг, аж ахуйн материал, шатах тослох материалын данс бүртгэлд бараа материалыг нэр төрөл, тоо хэмжээгээр нь ангилан бүртгээгүй нийт 20,643.0 мянган төгрөгийн бараа материалыг бөөн дүнгээр орлого авч бүртгэсэн байна.
2. Санхүүгийн байдлын тайлангийн оны эхний үлдэгдэлд тусгагдсан нийт хөрөнгийн дүн нь өр төлбөр цэвэр өмчийн дүнтэй 761.5 мянган төгрөгөөр, өмнөх оны санхүүгийн байдлын тайлангийн эцсийн үлдэгдэл нь тайлант оны эхний үлдэгдэлтэй 130,633.4 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан байна.
3. Санхүүгийн байдлын тайланд тусгагдсан тайлант үеийн үр дүн нь үр дүнгийн тайлан болон өмчийн өөрчлөлтийн тайланд тусгагдсан нийт үр дүнгээс 7,571.7 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна.
4. Санхүүгийн үр дүнгийн тайланд тусгагдсан цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлын дүн нь олговол зохих цалингийн дүнгээс 294,408.4 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.
5. Санхүүгийн үр дүнгийн тайлан болон мөнгөн гүйлгээний тайланд санхүүжилтийг 889,865.1 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн орлогыг 7,548.5 мянган төгрөг, нийт 897,413.6 мянган төгрөгийн орлого, зарлагыг дутуу тайлагнасан байна.

Аудитаар нийт 2,529.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 1 төлбөрийн акт тогтоов.

3.1 Төлбөрийн акт

1. Тайлант онд 1 ажилтны ээлжийн амралтын олговрыг 2,529.8 мянган төгрөгөөр илүү олгож, төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.3-д “хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь дуусгавар болж байгаа ажилтанд ажилласан хугацаанд ногдох ээлжийн амралтын тооцоо хийж, цалинг олгоно”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 тоот тушаалаар баталсан “Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам”-ыг тус тус зөрчсөн байна.

3.2 Албан шаардлага

1. Эрүүл мэндийн яамнаас хуваарилагдаж ирсэн эмнэлгийн зориулалттай 11 нэр төрлийн 51 ширхэг тоног төхөөрөмж, 3 нэр төрлийн 30 ширхэг тавилга, эд хогшлыг сумдад хуваарилсан боловч холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно;” Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4-д “хандив, тусламж, бэлэглэл, өвлөх журмаар олж авсан эд хөрөнгө;” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.
2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийцлийн аудитын асуудлаар хүргүүлсэн 2 албан шаардлагыг энэ тайлангийн 4.4.1, 4.3-д тусгасан болно.

3.3 Хариуцлага тооцох албан шаардлага

1. Аймгийн Засаг дарга Д.Аюурбунд: Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Дашнамжилмаад сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2026 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга Д.Аюурбунд даалгав.
2. Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Дашнамжилмаад: Эрүүл мэндийн газрын нягтлан бодогч Ц.Алтан-Өлзийд сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2026 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Дашнамжилмаад даалгав.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Аудитын явцад 1,351,431.6 мянган төгрөгийн 5 алдааг санхүүгийн тайланд залруулсан. Үүнд:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулагдаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа материалыг бөөн дүнгээр бүртгэсэн.	1	20,643.0			1	20,643.0	1	20,643.0				
Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэл өр төлбөр, өмчийн нийт дүн зөрүүтэй.	1	131,394.9			1	131,394.9	1	131,394.9				
Санхүүгийн байдлын тайлангийн үр дүн үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлангийн нийт үр дүн зөрүүтэй.	1	7,571.7			1	7,571.7	1	7,571.7				
Санхүүгийн тайлангийн цалин хөлс, нэмэгдлийн дүн цалингийн дэлгэрэнгүй олговол зохих цалингийн дүнтэй зөрүүтэй	1	294,408.4			1	294,408.4	1	294,408.4				
Санхүүгийн үр дүнгийн тайлан болон мөнгөн гүйлгээний тайлан дахь санхүүжилтийн дүн дутуу тайлагнагдсан.	1	897,413.6			1	897,413.6	1	897,413.6				
Дүн	5	1,351,431.6			5	1,351,431.6	5	1,351,431.6				

Аудитаар илэрсэн 4,080,497.9 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 2 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж, 2,529.8 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоолоо.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Амралтын цалин илүү олгосон.	1	2,529.8	1	2,529.8								
Эмнэлгийн зориулалттай үндсэн хөрөнгийн талаар холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй.	1	114,498.9			1	114,498.9						
Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Дашнамжилмаад сахилгын шийтгэл ногдуулах тухай.	1	-			1	-						
Эрүүл мэндийн газрын нягтлан бодогч Ц.Алтан-Өлзийд сахилгын шийтгэл ногдуулах тухай.	1	-			1	-						
Дүн	4	117,028.7	1	2,529.8	3	114,498.9						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд мэдээлэл байршуулаагүй орхигдуулсан.	1	3,938,999.0			1	3,938,999.0		
Дүн	1	3,938,999.0			1	3,938,999.0		
Төрийн хэмнэлтийн тухай хууль								
Төсвийн хөрөнгөөр автомашин худалдан авсан.	1	27,000.0			1	27,000.0		
Дүн	1	27,000.0			1	27,000.0		
Нийт дүн	2	3,965,999.0			2	3,965,999.0		

5. Аудитын тайлангийн хавсралт



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 03 сарын 16

Дугаар 242-А2370456
ХЭА-2026/098/НА-СТА-ТШЗ

Чингис хот

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагын Эрүүл мэндийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны 9 дүгээр сард төсвийн тодотголоор 27,000,000.00 (хорин долоон сая) төгрөгийн өртөг бүхий автомашин худалдан авах цахим тендер зохион байгуулж, төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д "Батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах," 13.1.2 дахь хэсэг "энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох," Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.", 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг хуульд заасан хугацаанд зохион байгуулдаггүй, төсвийг зориулалт бусаар зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Дашнамжилмаад даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ж.ГАНБААТАР

Х.БАЯРБААТАР



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 03 сарын 16

Дугаар 241-А/2370456

Чингис хот

ХЭА-2026/098/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд шилэн дансны цахим системд 3,938,998,982.00 (гурван тэрбум есөн зуун гучин найман сая есөн зуун ерэн найман мянга есөн зуун наян хоёр) төгрөгийн 26 гүйлгээг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 7 дугаар зүйлийн 7.1-т "Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" мэдээлнэ гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим системд мэдээллийг бүрэн байршуулдаггүй, хяналт тавьдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг эрхлэгчийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Дашнамжилмаа, нягтлан бодогч Ц.Алтан-Өлзий нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ж.ГАНБААТАР

Х.БАЯРБААТАР



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 83-А237 0456
ХЭА-2026/098/НА-СТА-ТШБ

Чингис хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 1 ажилтны ээлжийн амралтын олговрыг 2,529,760.00 (хоёр сая таван зуун хорин есөн мянга долоон зуун жаран) төгрөгөөр илүү олгож, төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.3-д “хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь дуусгавар болж байгаа ажилтанд ажилласан хугацаанд ногдох ээлжийн амралтын тооцоо хийж, цалинг олгоно”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 тоот тушаалаар баталсан “Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам”-ыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.” Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.3-д “Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Илүү олгосон 2,529,760.00 (Хоёр сая таван зуун хорин есөн мянга долоон зуун жаран) төгрөгийг нягтлан бодогч Ц.Алтан-Өлзийгөөр төлүүлж, аймгийн Төрийн сан банк дахь “Нэр заагдаагүй бусад орлого” 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Дашнамжилмаад хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

Ж.ГАНБААТАР
Х.БАЯРБААТАР



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16

Дугаар 243-А2370456
ХЭА-2026/098/НА-СТА-ТШЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагын Эрүүл мэндийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрүүл мэндийн яамнаас хуваарилагдаж ирсэн эмнэлгийн зориулалттай 11 нэр төрлийн 51 ширхэг тоног төхөөрөмж, 3 нэр төрлийн 30 ширхэг тавилга, эд хогшил 114,498,988.00 (нэг зуун арван дөрвөн сая дөрвөн зуун ерэн найман мянга есөн зуун наян найман) төгрөгийн хөрөнгийг сумдад хуваарилсан боловч данс бүртгэлээс хасаж, шилжүүлэх арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно;" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4-д "хандив, тусламж, бэлэглэл, өвлөх журмаар олж авсан эд хөрөнгө;" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хөрөнгөд бүртгэлтэй боловч данс бүртгэлээс хасалт хийгдээгүй хөрөнгүүдийг холбогдох хууль, журмын дагуу арга хэмжээ авч зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Дашнамжилмаа, нягтлан бодогч Ц.Алтан-Өлзий нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Х.БАЯРБААТАР



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 03 сарын 16

Дугаар 244-А2370456

Чингис хот

ХЭА-2026/098/НА-СТА-ТШЗ

Г Сахилгын шийтгэл ногдуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийгдсэн санхүүгийн тайлангийн аудитаар Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газар нь сөрөг дүгнэлт авсан болно.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, ...санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан ... нь тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.” гэж заасан байна.


Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т “Энэ хуулийн 42.1-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ.” гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Эрүүл мэндийн газрын нягтлан бодогч Ц.Алтан-Өлзийд сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2026 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Дашнамжилмаад даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ж.ГАНБААТАР

Х.БАЯРБААТАР